

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ
ХОЛБОГДСОН УЛСЫН ТӨСВӨӨС
САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛД АУДИТ
ХИЙЖ, ДҮГНЭЛТ ГАРГАХ

АУДИТЫН КОД: ГНАГ-2024/06-ШТА-НА

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Саранчимэг

Утас: 70273204 Цахим хаяг: saranchimegts@audit.gov.mn

Аудитор Т.Хүрэлбаатар

Утас: 70272248 Цахим хаяг: khurelbaatar@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ арга зүй, шалгуур үзүүлэлт	3
Аудит хийх үндэслэл:.....	3
Аудитын зорилт:.....	3
Аудитын хамрах хүрээ:.....	3
Аудитын арга зүй:	3
Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:.....	3
Аудит хийх хугацаа, бүрэлдэхүүн:.....	3
Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл:	4
Үндсэн мэдээлэл.....	4
БҮЛЭГ 1 Улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж хуваарилсан байна	5
1.1 Улсын төсвөөс олгох хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг бодитой тооцсон байна.....	5
1.2 Сонгуулийн хороодод зардлын төсвийг үндэслэлтэй хуваарилсан байна.....	8
БҮЛЭГ 2. УИХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг арвиан хэмнэлттэй зарцуулсан байна	10
2.1 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу, арвиан хэмнэлттэй зарцуулсан байна..	10
2.2 Зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан байна.....	10
2.3 Засгийн газрын нөөц хөрөнгөөс санхүүжүүлсэн зардал байхгүй байна.....	13
2.4 Хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна....	13
ДҮГНЭЛТ	14
ЗӨВЛӨМЖ	14

Товчилсон үгийн тайлбар

Товчилсон үг	Тайлал
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ГНАГ	Гүйцэтгэл нийцлийн аудитын газар
ГНАГ	Гүйцэтгэл нийцлийн аудитын газар
МТБ	Мэдээлэл технологийн баг
НА	Нийцлийн аудит
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СБА	Сонгуулийн байгууллагын ажилтан
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
УБЕГ	Улсын бүртгэлийн Ерөнхий газар
УИХ	Улсын Их Хурал
ЦЕГ	Цагдаагийн Ерөнхий газар
ШТА	Шууд тайлагнах аудит

Хүснэгтийн жагсаалт

<i>Хүснэгт 1 Монгол Улсын Их Хурлын 2024 оны сонгуулийн зардлын төсөв</i>	5
<i>Хүснэгт 2 Өмнөх сонгуулийн жилийн мэдээллийг 2024 оны сонгуулийн мэдээлэлтэй харьцуулсан байдал</i>	7
<i>Хүснэгт 3 Аймаг сумын сонгуулийн хорооны төсөв</i>	8
<i>Хүснэгт 4 Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст хуваарилсан төсвийн зарцуулалт</i>	9
<i>Хүснэгт 5 Төв аймгийн Цагдаагийн газарт хуваарилсан төсвийн зарцуулалт</i>	9
<i>Хүснэгт 6 УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн зардлын тайлан</i>	11

Графикийн жагсаалт

<i>График 1 Монгол Улсын Их Хурлын 2024 оны сонгуулийн зардлын төсөв</i>	6
<i>График 2 УИХ-ын сонгуулийн 2024 оны зардлыг 2020 онтой харьцуулсан байдал</i>	7
<i>График 3 Аймгийн сонгуулийн хорооны зардлын нийт дүнд эзлэх хувиар</i>	12
<i>График 4 Сумын сонгуулийн хорооны зардлын нийт дүнд эзлэх хувиар</i>	12

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудит хийх үндэслэл:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1,6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2023 оны А/162 дугаар тушаалыг тус тус үндэслэн “Сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах” сэдэвт аудитыг хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан Улсын Их Хурал, Засгийн газар, холбогдох байгууллагад танилцуулж, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэнэ. Үүнд:

- Улсын Их Хурлын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваариласан эсэх;
- Улсын Их Хурлын сонгуульд зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх;

Аудитын хамрах хүрээ:

Аудитад аймгийн Сонгуулийн хороо, сумын Сонгуулийн хороо, сумын сонгуулийн хэсэг, аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, аймгийн Цагдаагийн газар зэрэг байгууллагууд хамруулсан.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 400, 4000, Монгол улсын Төрийн аудитын стандарт-Нийцлийн аудит MNS 6817-7:2020, Нийцлийн болон Санхүүгийн аудитын арга зүйг ашиглан улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын талаар холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийн аудитын судалгаа, хөтөлбөр, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль, дэм, журам, зааврын холбогдох заалтуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд:

1. Төрийн аудитын тухай хууль
2. Төсвийн тухай хууль
3. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль
4. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль
5. Сонгуулийн төв байгууллагын тухай хууль
6. Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль
7. Дээрх хуулиудтай нийцүүлэн гаргасан тогтоол, журам
8. Батлагдсан төсөв, төсвийн хуваарь

Аудит хийх хугацаа, бүрэлдэхүүн:

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал удирдан, ахлах аудитор Ц.Саранчимэг аудитор Т.Хүрэлбаатар нар 2024 оны 07 дугаар сарын 08-аас 2024 оны 08 дугаар сарын 01-нийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв.

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл:

Аудитын ерөнхий зүйл, аудитын дүн, аудитын дүгнэлт, зөвлөмж, холбогдох газрын санал, хавсралт гэсэн агуулгаар бичигдсэн.

Үндсэн мэдээлэл

Төв аймгийн Сонгуулийн хороо нь Сонгуулийн ерөнхий хорооноос 2024 оны 06 дугаар сарын 18-аас 2024 оны 06 дугаар сарын 30-ны хооронд хуваарилсан нийт 1,087,579.0 мянган төгрөгийн санхүүжилтээс 917,918.0 мянган төгрөгийг 27 сумын сонгуулийн хороонд зарцуулах эрхийг олгож, 169,661.0 мянган төгрөгийг аймгийн Сонгуулийн хороо зарцуулахаар тус тус хуваарилсан байна.

Аргалант, Жаргалант, Өндөрширээт зэрэг нийт 7 сумын сонгуулийн хорооноос 95.6 мянган төгрөгийг аймгийн Сонгуулийн хороонд буцаан төвлөрүүлж, Аймгийн Сонгуулийн хороо нийт 33,804.1 мянган төгрөгийг Монгол улсын Сонгуулийн Ерөнхий хороонд буцаан төвлөрүүлжээ.

Аймгийн сонгуулийн хороо хуваарилсан зардлыг зориулалтын дагуу зарцуулж, зардал хооронд аль нэг зардлыг шилжүүлж ажиллаагүй байна.

Төв аймгийн Сонгуулийн хороо 9 гишүүн, нягтлан бодогч, бичиг хэргийн ажилтан нийт 11 ажилтан, аймгийн Сонгуулийн хорооны дэргэдэх Мэдээлэл технологийн багт 5 ажилтан, 27 сумын сонгуулийн хороонд 189 гишүүн, 126 даамал, 873 хэсгийн хорооны гишүүн нийт аймгийн хэмжээнд 1,502 төрийн албан хаагчид ажиллаж 745,976.0 мянган төгрөгийн урамшуулал олгогдсон байна.

УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар ЦЕГ, УБЕГ-т хуваарилсан зардлын төсвөөс Төв аймгийн Цагдаагийн газарт 56,336.0 мянган төгрөг, Улсын бүртгэлийн газарт 79,678.6 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсан байна.

**Улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу
Бүлэг 1 төлөвлөж хуваарилсан байна.**

Улсын төсвөөс олгох хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг холбогдох журмын дагуу тооцсон байна.

Сонгуулийн Ерөнхий Хорооны 2021 оны А/17 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих, журам”-ын 2.1-д заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн төсвийг зохих эдийн засгийн ангиллын дагуу сонгогчийн тоо, сум, дүүргийн болон хэсгийн хорооны тоо, тэдгээрт ажиллах ажилтнуудын тоог харгалзан аймаг, нийслэлийн сонгуулийн хороо бүрээр хуваарилсан байна.

СЕХ-ны 2024 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 3/562 дугаартай албан бичгийн 1 дүгээр хавсралтаар “Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны төсвийн зарцуулалтын тухай тайлбар” 2 дугаар хавсралтаар “Монгол Улсын Их Хурлын 2024 оны сонгуулийн Төв аймгийн сонгуулийн хорооны төсвийн хуваарь”-ийг ирүүлсэн байна. Энэхүү төсвийн хуваарьт Төв аймгийн сонгуулийн хороо нь 1,076,923.0 мянган төгрөгийн зардал гаргахаар төсөвлөгдсөн байна.

СЕХ-ны 2024 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 3/667 дугаартай албан бичгийн 1 дүгээр хавсралтаар Төв аймгийн сонгуулийн хорооны зардал 1,087,579.0 мянган төгрөг болж 10,656.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, НДШ 9,856.0 мянган төгрөг, хоолны зардал 800.0 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

СЕХ-оос төсөв хуваарилсан тухай бүрд зардал тус бүрийг тооцоолсон аргачлал, зөвлөмжийг ирүүлсэн ба үүнд үндэслэн сумдын хэсгийн хороодод төсвийг хуваарилсан байна.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны сонгуулийн зардлын төсөв

Хүснэгт №1

/мянган төгрөгөөр/


№	Зардлын нэр	Нийт Төсөв
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	300.0
2	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт,	14,278.0
3	МТБ, даамлын сургалтын зардал	25,840.0
4	Аймаг, сум, хэсгийн хорооны бичиг хэргийн зардал	16,690.0
5	Аймаг, сум, хэсгийн хорооны шуудан холбооны зардал	19,600.0
6	Аймаг, сум, хэсгийн хорооны унааны зардал	83,580.0
7	Санал авах байр, Төрийн далбаа бэлтгэх зардал	30,070.0
8	Сурталчилгааны зардал	8,000.0
9	Саналын хуудас, төхөөрөмж авах, хүргэх ачаа, томилолтын зардал	52,570.0
10	Мэдээлэл технологийн багийн гишүүний холбоо, унааны зардал	1,300.0
11	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, НДШ	665,280.0
12	Мэдээллийн технологийн багийн гишүүн даамлын урамшуулал, хоолны зардал	80,696.0
13	Хоолны зардал	60,550.0
14	Томилолтын зардал	17,383.0
15	Шуурхай багийн зардал	2,130.0
16	Болзошгүй зардал	9,312.0
	Нийт дүн	1,087,579.0

Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хорооноос ирсэн албан бичиг

Монгол Улсын Их Хурлын 2024 оны сонгуулийн зардлын төсөв

График №1

/мянган төгрөгөөр/



Аймгийн Сонгуулийн хороонд нийт 1,087,579.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 917,918.0 мянган төгрөгийн 27 сумын сонгуулийн хороодод, 169,661.0 мянган төгрөгийг аймгийн сонгуулийн хороонд зарцуулахаар хуваарилсан байна.

Өмнөх 2020 оны УИХ-ын сонгуулиар аймгийн сонгуулийн хороонд 535,293.0 мянган төгрөг хуваарилагдан зарцуулагдсан бол 2024 онд 1,087,579.0 мянган төгрөг болж 541,630.0 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь Сонгуулийн хорооны гишүүдийн болон Мэдээлэл технологийн баг, даамлын урамшуулал, НДШ 383,430.0 мянган төгрөгөөр, саналын хуудас төхөөрөмж авах, хүргэх ачаа томилолтын зардал 33,130.0 мянган төгрөгөөр, унааны зардал 24,380.0 мянган төгрөгөөр, сургалтын зардал 16,897.0 мянган төгрөгөөр, томилолтын зардал 10,236.0 мянган төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой байна.

Сонгуулийн зардал өссөн нь 2020 оны хэсгийн хорооны тоо 2024 оныхтой харьцуулахад Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль өөрчлөгдсөнтэй холбоотой сонгуулийн байгууллагын ажилтны тоо аймгийн хэмжээнд 2020 онд 996 төрийн албан хаагч ажиллаж байсан бол 2024 оны УИХ-ын сонгуулийг зохион байгуулахад 1211 төрийн албан хаагч ажиллаж 215-аар нэмэгдсэнтэй холбоотой байна.

Монгол улсын их хурлын сонгуулийн тухай хуулийн 16 дугаар зүйл Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны эрх, 16.1-д “Сонгуулийн ерөнхий хороо санал авах өдрөөс 70-аас доошгүй хоногийн өмнө аймаг, нийслэлийн сонгуулийн хороог тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ирүүлсэн саналыг харгалзан дарга, нарийн бичгийн дарга болон тав, эсхүл долоон гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, нийтэд мэдээлнэ” гэсэн заалтын дагуу сумын сонгуулийн хороог 7 гишүүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулсантай холбоотойгоор өмнөх сонгуулиас 52 албан хаагчаар өссөн байна.

Монгол улсын их хурлын сонгуулийн тухай хуулийн 18 дугаар зүйл хэсгийн хорооны чиг үүрэг, 18.1-д “Сум, дүүргийн сонгуулийн хороо хэсгийн хороог санал авах өдрөөс 45-аас

доошгүй хоногийн өмнө дарга болон зургаа, эсхүл найман гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд нийтэд мэдээлнэ.” гэсэн заалтын дагуу сумын сонгуулийн хэсгийн хороог 9 гишүүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулсантай холбоотойгоор өмнөх сонгуулиас 152 албан хаагчаар өссөн байна.

Сонгуулийн байгууллагын ажилтны тоо нэмэгдсэнээс гадна 2020 оноос хойш Монгол улсад хөдөлмөр хөлсний доод хэмжээ 3 удаа шинэчлэгдсэнтэй холбоотой нэг ажилтанд олгосон урамшууллын хэмжээ дунджаар 130.0 мянган төгрөгөөр өссөн нь Сонгуулийн хорооны гишүүдийн болон Мэдээлэл технологийн баг, даамлын урамшуулал, НДШ-ийн зардал өсөхөд нөлөөлсөн байна.

Өмнөх сонгуулийн жилийн мэдээллийг 2024 оны сонгуулийн мэдээлэлтэй харьцуулсан байдал


Хүснэгт №2 /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Сонгуулийн жил				
	2020 он	2024 он	Өссөн		
			Дүн	Хувь	
Төрийн албан хаагчидын тоо	996	1211	215	17.75%	
Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ /төгрөг/	420,000.0	660,000.0	240,000.0	36.36%	
Шатахууны үнэ	бензин А-92	1,377.0	2,423.2	1046.2	43.17%
	дизелийн түлш	1,860.0	3,592.7	1732.7	48.23%

Эх сурвалж: Статистикийн бюллетень танилцуулга

Өмнөх сонгуулийн зардлыг 2024 оны сонгуулийн зардалтай харьцуулахад аймгийн сонгуулийн хорооны зардал 88,353.0 мянган төгрөгөөр буюу 47.9 хувь, 27 сумын сонгуулийн хорооны зардал 463,933.0 мянган төгрөгөөр буюу 49.5 хувь өссөн байна.

УИХ-ын ээлжит сонгуулийн 2024 оны зардлыг 2020 онтой харьцуулсан байдал



СЕХ-оос төсвийн санхүүжилтийг тухайн аймгийн газар нутгийн хэмжээ, сонгогчийн болон сум, хэсгийн тоо, тэдгээрт ажиллагсдын тоо зэргийг харгалзан тооцож олгосон байна.

УИХ-ын ээлжит сонгуулийг зохион байгуулахтай холбоотой зардлыг УБЕГ-ын төсөвт баталснаас Төв аймагт 79,678.6 мянган төгрөг хуваарилахаар төсөвлөгдсөн байна.

Сонгуулийн хороодод зардлын төсвийг үндэслэлтэй хуваарилсан байна.

Аймгийн сонгуулийн хорооноос сумдын сонгуулийн хороо, хэсгийн хороодын зардлыг хуваарилахдаа сумдын хэсгийн хорооны тоо, санал авах байрны тоо, Төв аймгийн сонгуулийн хорооны гишүүн, бичиг хэргийн ажилтан, мэдээлэл технологийн багийн ажилтан, 27 сумын сонгуулийн хорооны гишүүн, даамал, хэсгийн хорооны гишүүн зэрэг нийт ажиллагсдын тоонд үндэслэн СЕХ-ноос ирүүлсэн аргачлал зөвлөмжийн дагуу тооцож хуваарилсан байна.

Төв аймгийн Сонгуулийн хороо нь Сонгуулийн ерөнхий хорооноос 2024 оны 4 дүгээр сарын 16-аас 2024 оны 6 дугаар сарын 30-ны хооронд хуваарилсан нийт 1,087,579.0 мянган төгрөгийн санхүүжилтээс 917,918.0 мянган төгрөгийг сумын сонгуулийн хороонд, 169,661.0 мянган төгрөгийг аймгийн Сонгуулийн хороонд зарцуулахаар тус тус хуваарилсан байна.

Аймаг сумын сонгуулийн хорооны төсөв

Хүснэгт №3

№	Зардлын нэр	/мянган төгрөгөөр/		
		Нийт Төсөв	Аймаг төсөв	Сум төсөв
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	300.0	300.0	
2	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	14,278.0	14,278.0	
3	МТБ, даамлын сургалт	25,840.0	25,840.0	
4	Бичиг хэргийн зардал	16,690.0	1,000.0	15,690.0
5	Шуудан холбооны зардал	19,600.0	1,000.0	18,600.0
6	Унаа	83,580.0	21,230.0	62,350.0
7	Санал авах байр бэлтгэх зардал	30,070.0		30,070.0
8	Сурталчилгааны зардал	8,000.0	8,000.0	
9	Саналын хуудас, санал тоолох төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх зардал	52,570.0	52,570.0	
10	МТБ-ийн гишүүний холбоо, унааны зардал	1,300.0	1,300.0	
11	Сонгуулийн хорооны гишүүний урамшуулал, НДШ	665,280.0	11,088.0	654,192.0
12	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, НДШ	80,696.0	3,080.0	77,616.0
13	Хоолны зардал	60,550.0	1,150.0	59,400.0
14	Томилолтын зардал	17,383.0	17,383.0	
15	Шуурхай багийн зардал	2,130.0	2,130.0	
16	Болзошгүй зардал	9,312.0	9,312.0	
	Нийт дүн	1,087,579.0	169,661.0	917,918.0

Эх сурвалж: Аймаг сумын сонгуулийн хорооны анхан шатны баримтаас

Аймгийн сонгуулийн хороонд зарцуулах зардлаас сонгуулийн байгууллагын ажилтан, мэдээлэл технологийн гишүүн, даамлын сургалтын зардалд 40,118.0 мянган төгрөг буюу 23,64%, саналын хуудас, санал тоолох төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх зардал 52,570.0 мянган төгрөг буюу 30,98%, аймгийн сонгуулийн хорооны унааны зардалд 21,230.0 мянган төгрөг буюу 12,51%, томилолтын зардал 17,383.0 мянган төгрөг буюу 10,24%, сонгуулийн байгууллагын ажилтан, мэдээлэл технологийн гишүүний урамшуулал, НДШ-д 14,168.0 мянган төгрөг буюу 8,35 хувийг тус тус эзэлж байгаа нь нийт зардлын 15,59%-ийг байна.

УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар УБЕГ-т хуваарилсан зардлын төсвөөр Төв аймгийн Улсын бүртгэлийн газарт 84,518.6 мянган төгрөг төсөвлөгдсөнөөс нэмэлт санхүүжилтийн дансанд санхүүжилтийг бүрэн авч 100 хувь зарцуулсан байна. УИХ-ын сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд худалдан авсан шатахууныг бүрэн зарцуулж үлдэгдэлгүй, нийт 31 төрлийн 270 ширхэг бичиг хэргийн материалын үлдэгдэлтэй байна.

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст хуваарилсан төсвийн зарцуулалт

Хүснэгт №4

/мянган төгрөгөөр/

№	Зардлын нэр	Төсөв	Зарцуулалт	Хэмнэлт
1	Цалин, НДШ-ын зардал	54,890.0	54,890.0	0.0
2	Шатахууны зардал	6,240.0	5,000.0	1,240.0
3	Албан томилолтын зардал	16,428.0	17,728.0	-1,300.0
4	Автомашинны түрээсийн зардал	1,500.0	1,500.0	0.0
5	Цайны зардал	960.0	900.0	60.0
6	Бичиг хэргийн зардал	4,000.6	4,000.6	0.0
7	Шуурхай багийн зардал	500,000	500,000	0.0
	Нийт дүн	84,518.6	84,518.6	0.0

УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар ЦЕГ-т хуваарилсан зардлын төсвөөр Төв аймгийн Цагдаагийн газарт 56,336.6 мянган төгрөг төсөвлөгдсөнөөс нэмэлт санхүүжилтийн дансанд санхүүжилтийг бүрэн авч 100 хувь зарцуулсан байна.

Төв аймгийн Цагдаагийн газарт хуваарилсан төсвийн зарцуулалт

Хүснэгт №5

/мянган төгрөгөөр/

№	Зардлын нэр	Төсөв	Зарцуулалт	Хэмнэлт
1	Хоолны зардал	38,376.0	38,376.0	0.0
2	Шуудан холбооны зардал	15,960.0	15,960.0	0.0
3	Шатахууны зардал	2,000.0	2,000.0	0.0
	Нийт дүн	56,336.0	56,336.0	0.0

Бүлэг 2

УИХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулсан байна.

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу, арвилан хэмнэлттэй зарцуулсан байна.

Сонгуулийн ерөнхий хорооноос 9-н удаагийн санхүүжилтээр нийт 1,087,579.0 мянган төгрөгийн батлагдсан төсвийг бүрэн авсан байна. Аймгийн сонгуулийн хорооны төрийн сан дахь 100140022001 тоот дансаар 2024 оны 04 дүгээр сарын 30-аас 2024 оны 07 дугаар сарын 05-ны хооронд 1,053,679.3 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж үлдэгдэл 33,899.7 мянган төгрөгийн хэмнэлтийг Сонгуулийн ерөнхий хороонд буцаан төвлөрүүлсэн байна.

Аргалант сум 45.9 мянган төгрөг, Батсүмбэр сум 2.4 мянган төгрөг, Баянцагаан сум 0.8 мянган төгрөг, Бүрэн сум 2.9 мянган төгрөг, Дэлгэрхаан сум 4.5 мянган төгрөг, Жаргалант сум 8.4 мянган төгрөг, Өндөрширээт сум 30.6 мянган төгрөг нийт 95.6 мянган төгрөгийн төсвийн үлдэгдлийг буцаан аймгийн сонгуулийн хорооны дансанд төвлөрүүлж, аймгийн сонгуулийн хороо 33,804.1 мянган төгрөгийг хэмнэлт, нийт 33,899.7 мянган төгрөгийг Сонгуулийн ерөнхий хорооны 100900022001 дансанд 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдөр төвлөрүүлсэн бол бусад сумд батлагдсан төсвийн хэмжээнд тулгаж зарцуулсан байна.

Төсвийг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй зарцуулсан байдлыг сумдын сонгуулийн хороодоос ирүүлсэн төсвийн зарцуулалтын тайлан, материалын тайлан аймгийн сонгуулийн хорооны төсвийн зарцуулалтын нэгтгэсэн тайлангуудаас үзэж шалгав.

Хэмнэгдсэн төсвийг зардал тус бүрээр авч үзвэл, саналын хуудас, санал тоолох төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх зардал 6,646.2 мянган төгрөг, аймаг, сум, хэсгийн хорооны унааны зардал 8,331.6 мянган төгрөг, болзошгүй зардал 9,312.0 мянган төгрөг, томилолтын зардал 7,413.0 мянган төгрөг, шуурхай багийн зардал 2,130.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан байна.

Аймгийн болон сумдын Сонгуулийн хороод Сонгуулийн Ерөнхий хорооны даргын 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын дагуу хуваарилагдсан төсвийн гүйцэтгэлийг бодитой тайлагнасан байна.

Аймгийн сонгуулийн хороонд 169,661.0 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 135,856.9 мянган төгрөг, сумдын сонгуулийн хороонд 917,918.0 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 917,822.4 мянган төгрөгийг зарцуулж, зардлыг эдийн засгийн ангиллаар тайлагнасан байна.

УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн зардлын тайлан

Хүснэгт №6

/мянган төгрөгөөр/

№	Зардлын нэр	Нийт Төсөв	Аймаг гүйцэтгэл	Сум гүйцэтгэл	Нийт үлдэгдэл
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	300.0	300.0		
2	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	14,278.0	14,278.0		
3	МТБ, даамлын сургалт	25,840.0	25,840.0		
4	Бичиг хэргийн зардал	16,690.0	1,000.0	15,690.0	2.9
5	Шуудан холбооны зардал	19,600.0	1,000.0	18,600.0	
6	Унаа	83,580.0	12,931.0	62,317.4	8,331.6
7	Санал авах байр бэлтгэх зардал	30,070.0		30,009.9	60.1
8	Сурталчилгааны зардал	8,000.0	7,996.1		3.9
9	Саналын хуудас, санал тоолох төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх зардал	52,570.0	45,923.8		6,646.2
10	МТБ-ийн гишүүний холбоо, унааны зардал	1,300.0	1,300.0		
11	Сонгуулийн хорооны гишүүний урамшуулал, НДШ	665,280.0	11,088.0	564,192.0	
12	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, НДШ	80,696.0	3,080.0	77,616.0	
13	Хоолны зардал	60,550.0	1,150.0	59,400.0	
14	Томилолтын зардал	17,383.0	9,970.0		7,413.0
15	Шуурхай багийн зардал	2,130.0			2,130.0
16	Болзошгүй зардал	9,312.0			9,312.0
	Нийт дүн	1,087,579.0	135,856.9	917,822.4	33,899.7

Аймгийн сонгуулийн хорооны зардлын нийт дүнд эзлэх хувиар
График №3



Сум сонгуулийн хороодод зарцуулах зардлаас сум, хэсгийн хорооны гишүүний урамшуулал 564,192.0 мянган төгрөг буюу 61,5%, мэдээллийн технологийн багийн гишүүн, даамлын урамшуулал 77,616.0 мянган төгрөг буюу 8,5%, хоолны зардал 59,400.0 мянган төгрөг буюу 6,5%, сумын сонгуулийн хорооны унааны зардал 62,317.4 мянган төгрөг буюу 6,8%, санал авах байр бэлтгэх зардал, шуудан холбооны зардал, бичиг хэргийн зардал 64,299.9 мянган төгрөг буюу 7,0% байгаа нь нийт зардлын 87,1%-ийг эзэлж байна.

Сумын сонгуулийн хорооны зардлын нийт дүнд эзлэх хувиар
График №4



Засгийн газрын нөөц хөрөнгөөс санхүүжүүлсэн зардал байхгүй байна.

Засгийн газрын нөөц хөрөнгөнөөс санхүүжүүлсэн зардал байхгүй бөгөөд харин Сонгуулийн ерөнхий хорооноос батлагдаж ирсэн болзошгүй зардал 9,312.0 мянган төгрөгийг зарцуулалгүй буцаан төвлөрүүлсэн байна.

Хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Сонгуулийн Ерөнхий хорооны даргын 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 3.10-д аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь сум, дүүргийн сонгуулийн хорооны, төв комисс нь салбар комиссын сонгуулийн зардлын зарцуулалтад тус тус хяналт тавина гэж заасны дагуу хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Сонгуулийн зардлыг бодитой тооцож, зориулалтын дагуу зарцуулж тайлагнасан байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн Аймгийн сонгуулийн хорооны дарга М.Отгонбат, нягтлан бодогч Э.Бүжинлхам нарт зөвлөх нь:

1. Сонгуулийн зардалд санал авах байрыг тохижуулахтай холбоотой авсан бараа материалыг дараагийн сонгуульд тухайлбал орон нутгийн сонгуульд ашиглаж, төсвийг хэмнэх талаар зохион байгуулж ажиллах.
2. Сонгуулийн Ерөнхий хорооны даргын 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/17 дугаар захирамжаар баталсан "Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам"-ын 4.7-д заасны дагуу баримтыг хүлээн авахдаа хэсгийн хорооны зардлыг төсөвтэй тулган шалгаж, анхан шатны баримтын бүрдлийг нягтлан шалгаж акт үйлдэж байх.

Тайлан хянасан:

Дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал
Аудитын менежер О.Амаржаргал

Тайлан бичсэн:

Ахлах аудитор Ц.Саранчимэг
Аудитор Т.Хүрэлбаатар

4117144522
НЮА0064 9060464

УИХ-ын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлсэн

/мян.төг/

№	Зардлын нэр	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Сонгуулийн дүн мэдээний маягт, албан бичгийн хэвлэмэл хуудас, үнэмлэх хэвлүүлэх зардал	300,000.00	300,000.00	
2	Сонгуулийн бичиг баримт, техник хэрэгсэл болон сурталчилгааны материалыг аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо, санал авах байранд хүргэх, буцаан татах зардал	52,570,000.00	45,923,779.00	6,646,221.00
3	Сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой гарах зардал			
4	Дүн мэдээ дамжуулах зардал	2,130,000.00	-	2,130,000.00
5	Санал авах байр бэлтгэх, тохижуулах зардал	30,070,000.00	30,009,904.00	60,096.00
6	Сургалт, сурталчилгааны зардал	48,118,000.00	48,114,118.00	3,882.00
7	Сонгуулийн байгууллагын ажилтан болон мэдээлэл технологийн багийн гишүүн, даамал, нөөц даамлын тухайн сонгуулийн байгууллагад ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал	806,526,000.00	806,526,000.00	
8	Бичиг хэргийн зардал	16,690,000.00	16,687,100.00	2,900.00
9	Шуудан холбооны зардал	19,600,000.00	19,600,000.00	
10	Унааны зардал	84,880,000.00	76,548,400.00	8,331,600.00
11	Албан томилолтын зардал	17,383,000.00	9,970,000.00	7,413,000.00
12	Болзошгүй зардал	9,312,000.00	-	9,312,000.00
13	Нэмэлт Хяналтын тооллого хийсэн нийслэл, дүүрэг, хэсгийн хорооны гишүүдийн хоолны зардал			
14	Нэмэлт Хяналтын тооллого хийсэн хэсгийн хорооны унааны зардал			
15	Саналын хуудас устгах зардал			
НИИТ ДҮН		1,087,579,000.0	1,053,679,301.0	33,899,699.0

Жич: Аймаг, нийслэл дэх төрийн аудитын байгууллага тойрог тус бүрээр нэгтгэн ирүүлнэ.

Судалгаа нэгтгэсэн: Аудитор

Т.Хүрэлбаатар

Судалгаа хянасан: Аудитын менежер

О.Амаржаргал


Огноо:

4117144522
НЮА9064 9060464

УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийг харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах, сонгуулийн хорооны зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Тойргийн дугаар	Мандатын тоо	Аймаг, Нийслэлийн сонгуулийн хорооны нэр	Сум, дүүргийн сонгуулийн хорооны тоо	Хэсгийн хорооны тоо	Сонгуулийн насны иргэдийн тоо	Сонгууль өгсөн иргэдийн тоо	Батлагдсан төсөв /мянган төгрөг/	Зардлын гүйцэтгэл /мянган төгрөг/	Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/
	5	10	Төв	27	97	60,365	41,116	1,087,579	1,053,679.3	33,899.7
			Сэлэнгэ							
			Дархан							
	Тойргийн дүн									

Судалгаа нэгтгэсэн: Аудитор



Судалгаа ханасан: Аудитын менежер

Т.Хүрэлбаатар



О.Амаржаргал



УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийг харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулсан сонгуулийн хорооны удирдах албан тушаалтны талаарх судалгаа

№	Сонгуулийн хорооны нэр	Сонгуулийн хорооны дарга			Сонгуулийн хорооны нягтлан бодогч				
		Овог, Нэр	Томилогдсон тушаалын огноо, дугаар	Мэргэжил	Эрхлэж буй ажил, албан тушаал	Овог, Нэр	Томилогдсон тушаалын огноо, дугаар	Мэргэжил	Эрхлэж буй ажил, албан тушаал
1	Төв аймаг	Моломын Отгонбат	2024.04.16 №23	Газар зохион байгуулагч	Төв аймгийн ЗДТГ-ын дарга	Энхтөрийн Бужинлхам	2024.04.17 №01	Нягтлан бодогч	Төв аймгийн ЗДТГ-ын нягтлан бодогч

Судалгаа нэгтгэсэн: Аудитор

Т.Хүрэлбаатар

Судалгаа хянасан: Аудитын менежер

О.Амаржаргал



Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлийн маягт

Аудитын нэр: Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах
 Аудитын код: ГНАГ-2024/06-ШТА-НА
 Байгууллагын нэр: Төв аймаг дахь Төрийн аудитын газар

№	Аудитын чиглэл /Асуулт/	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /мянган төгрөг/	Аудитын байгууллагаас гаргасан шийдвэр	Шалгагдагч байгууллагын санал, тайлбар	Гаргасан шийдвэр
A	1	2	3	4	5	6
1	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу, арвилан хэмнэлттэй зарцуулсан уу?	УИХ-ын сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд худалдан авсан шатахууныг бүрэн зарцуулж үлдэгдэлгүй, нийт 31 төрлийн 270 ширхэг бичиг хэргийн материалын үлдэгдэлтэй байна.		Зөвлөмж өгсөн	Тайлбар ирүүлээгүй	Зөвлөмж өгсөн
2	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу, арвилан хэмнэлттэй зарцуулсан уу?	Хэсгийн хороодын баримтыг хүлээн авахдаа зардлыг төсөвтэй тулган шалгаж, анхан шатны баримтын бүрдлийг нягтлан шалгаж акт үйлдээгүй байна.		Зөвлөмж өгсөн	Тайлбар ирүүлээгүй	Зөвлөмж өгсөн

Бэлтгэсэн: 
 Анхан шатанд хянасан: 
 Овог нэр:
 Огноо:
 4117144527
 НСОА0064 0800464

Т.Хүрэлбаатар

О.Амаржаргал

Танилцаж зөвшөөрсөн:

Албан тушаал: 
 Овог нэр: Т.Бүжimbayev
 Огноо:

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273465
И-мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn